

/ГЭРЛЭЛТ ЦУЦЛУУЛЖ, ХҮҮХДИЙН АСРАМЖ ТОГТООЛГОХ,

ТЭТГЭЛЭГ ГАРГУУЛАХ ТУХАЙ/

Дорноговь аймаг дахь сум дундын Иргэний хэргийн

анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргах нь

___он___сарын___ны өдөр
сум

Сайншанд

Нэхэмжлэгч: Боржгон овогт Ч. Т, Дорноговь аймгийн Сайншанд сумын 1 дүгээр баг Аюушийн 1-1 тоотод оршин суух, утас 23567, 9987006 /ажлын газрын хаяг, албан тушаал/

Хариуцагч: Боржгон овогт У. Д, Ажлын газрын хаяг:Аймгийн Засаг даргын Тамгын газрын жижүүр, Дорноговь аймгийн Сайншанд сумын 2 дугаар баг 2-58 айлын 21 тоот оршин суух, утас 23587, 99790507 Шинэ хаягийг заавал бичих

Нэхэмжлэлийн шаардлага: Гэрлэлт цуцлуулж, хүүхдийн асрамж тогтоолгох, хүүхдийн тэтгэлэг гаргуулах тухай

Нэхэмжлэлийн үндэслэл: Ч.Т миний бие 2005 онд У.Д-тэй танилцан 2007 оны 12 дугаар сарын 01-нд гэрлэлтийн 011 тоот батлагаагаар бүртгүүлж гэр бүл болсон билээ. Биднийг гэр бүл байх хугацаанд 2009 оны 1 дүгээр сарын 12-нд хүү Д.Одбаяр, 2010 оны 11 сарын 05-нд охин Д.Цэцэг нар төрсөн.

Манай нөхөр У.Д 2008 оноос эхлээд архи их уух болсон. Согтохоор гэрийн эд зүйлийг зарах, эвдэх, мөн намайг болон хүүхдүүдийг зодох болсон. Иймээс бид цаашид гэр бүл байх боломжгүй тул гэрлэлтийг цуцалж өгнө үү. Хүүхдүүдийг миний асрамжид үлдээж, эцэг Д-өөс хүүхдийн тэтгэлэг гаргуулж өгнө үү. Бидний хооронд эд хөрөнгийн маргаан байхгүй.

Нэхэмжлэл гаргасан /гарын үсэг/ Ч.Т

Нэхэмжлэлд: 1.Гэрлэлтийн гэрчилгээний хуулбар 1 хувь /нотариатаар гэрчлүүлэх/

2.Хүүхдийн төрсний гэрчилгээний хуулбар 1 хувь/нотариат/

3.Өрхийн эмчийн тодорхойлолт 1 хувь

4.Багийн Засаг даргын тодорхойлолт

5.Сургуулийн тодорхойлолт

6.Эд хөрөнгийн маргаантай бол дундын эд хөрөнгө болон хуваарьт өмчийн жагсаалт

7.Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт 1хувь

8. Иргэний үнэмлэхний хуулбар /нотариатаар батлуулсан/

Улсын тэмдэгтийн хураамж төлөхдөө шүүхэд хандах болон Дорноговь аймгийн Татварын газарт хандан төлбөрийн даалгавар үүсгүүлж хураамжаа банкинд тушаана.

Шүүхийн утас: 70522144, 92172020

Нэхэмжлэл 2% зэргийг хавсаргав. **Анхаарах:**/Та цаасны зүүн захаас 30 мм, дээд, доод захаас 20мм, баруун захаас 15 мм зайтай бичнэ/Нотлох баримтыг эх хувиар нь өгөх боломжгүй бол нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг гаргаж өгнө/